



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/93 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.8-д “... хамгийн сайн үнэлгээ авсан банкныг шалгаруулна. ...” гэснийг “... хамгийн сайн үнэлгээ авсан 2-3 банкныг шалгаруулна. ...” гэж, 4.1-д тусгасан хүснэгтийн 8-ын 17 дахь хэсэгт “Жижиг зээлийн банкинд байршуулах нийт эх үүсвэрт тооцох хүүгийн хувь, хэмжээг хүлээн зөвшөөрсөн тухай нотолгоо” гэснийг “Жижиг зээлийн банкинд байршуулах нийт эх үүсвэрт эсхүл эх үүсвэрийн үлдэгдэлд тооцох хүүгийн хувь, хэмжээг хүлээн зөвшөөрсөн тухай нотолгоо” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Мөн хавсралтын 5 дахь хэсгийг бүхэлд нь дор дурдсан агуулгаар өөрчилсүгэй:
“Тав. Банкнд байршуулах зээлийн нийт эх үүсвэрт болон эх үүсвэрийн үлдэгдэлд тооцох хүү


5.1 Жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэхээр шалгарсан банкинд байршуулах зээлийн нийт эх үүсвэрт болон эх үүсвэрийн үлдэгдэлд тооцох хүүгийн хувь, хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан үнэлгээний хороо тогтооно.

5.2 Үнэлгээний хороо 5.1-д заасан хувь, хэмжээг тогтооходоо инфляцийн түвшин, захиргааны холбогдох зардал болон эрсдэлийн хувь зэргийг харгалзан үзэж болно.

5.3 Үнэлгээний хороо хүн амын төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих бодлогын хүрээнд аймгуудад олгох зээлийн нийт эх үүсвэрийн зөвхөн үлдэгдэлд хүү тооцож болно.”

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийн банкинд шилжүүлсэн эх үүсвэрт тооцох хүүг тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/128 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т. АЮУРСАЙХАН

151221903